

## ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2021 оны 02 дугаар сарын 10-ны өдөр

1. “Монголросцветмет” ТӨҮГ нь Шилийн цахар-Баргилт цехийн 35кВ-ын 2.5 км ЦДАШ, Баргилт уурхайд 35/6кВ-ын 2х1600кВА-ын чадалтай дэд өртөөний техникийн нөхцөл авах, зураг төсөл боловсруулж батлуулах зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.
2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Хэнтий аймгийн Дархан сумын нутагт орших MV-016657 тоот “Баргилт” талбайд Шилийн цахар-Баргилт цехийн 35кВ-ын 2.5 км ЦДАШ, Баргилт уурхайд 35/6кВ-ын 2х1600кВА-ын чадалтай дэд өртөөний техникийн нөхцөл авах, зураг төсөл боловсруулж батлуулах зөвлөх үйлчилгээний ажлыг хийж гүйцэтгэснээр ТӨҮГ-ын харъяа Баргилтын уурхайн үйлдвэрийн бүтээмжийг өсгөх болно.
3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх хуулийн этгээд нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:
  - Байгууллагын ерөнхий танилцуулга
  - Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /нотариатаар гэрчлүүлсэн/
  - Зөвлөх хуулийн этгээдийн санхүүгийн чадавхийн мэдээлэл /сүүлийн 2 жилийн буюу 2019, 2020 оны санхүүгийн тайлан ирүүлэх/,
  - Татвар, нийгмийн даатгалын газар, ШШГЕГ болон банкны тодорхойлолт зэргийг тендер зарласан өдрөөс хойшхи байдлаар/ ирүүлнэ.
  - Чадварыг нэмэгдүүлж, сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.
  - Сүүлийн 2 жил ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл, ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт эсхүл гэрээт ажлыг бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт.
4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 10 цагаас өмнө авч болох бөгөөд мэдүүлгийг 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 14 цагаас өмнө цахим худалдан авах ажиллагааны систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар ирүүлнэ.
5. Тендерийг 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 14.20 цагт цахимаар нээнэ.

**“Монголросцветмет” ТӨҮГ**

**Хаяг: Улаанбаатар хот 51, ш/х – 002**

**Баянзүрх дүүрэг, Энх тайвны өргөн чөлөө.**

**22-р хороо, “Монголросцветмет” ТӨҮГ-ын байр, 504 тоот,**

**И-мейл: [mailbox@monros.mn](mailto:mailbox@monros.mn).**

**Утас/факс: 976-11-458380(ф), 976-11-458675, 976-11-450060-158**